

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛИЙН ТҮҮВЭР**

2025 оны 12 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга		№	Зүйл, заалт	Хариуцах байгууллага	Биелэлт	Дүн
	1	2					
1	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд		1	1.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй, шуурхай, гүйцэд эцэслэн шийдвэрлэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага нарт;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нар	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ер.ulaanbaatar.mn системээр нийт 33 өргөдөл бүртгэгдсэн. Үүнээс 32 өргөдөл гомдлыг 100% хууль зүйн үндэслэлтэй эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд 1 өргөдөл судлагдаж байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 95%-тай байна.	95%
2	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд		1	7.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдол болон хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг харгалзан үзэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нар	Байгууллагын нийт 74 албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдол болон хариутай албан бичгийн шийдвэрлэлт, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, ур чадвар, төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлага зэргийг харгалзан үзэж үр дүнг үнэлж дүгнэн ур чадварын урамшууллыг тооцон олгож байна.	100%
3	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэлд:		1	1.Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 21, 22 дугаар байр, Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 1-48, 2-48, 4-48 дүгээр байр,	Улаанбаатар орон сууцжуулалт ХХК	Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 21 дүгээр байрны төсөл хэрэгжүүлэгчээр "Тод сүндэрэл" ХХК шалгарч барилгыг буулгаагүй, иргэдтэй харилцан тохиролцож 2 болон 3 талт гэрээ хийх бэлтгэл ажил хийгдэж байна. 22 дугаар байрны төсөл хэрэгжүүлэгчээр "Хан хөгшин	100%

				Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах СТ-4 дүгээр байрыг тус тус буулган дахин барилгажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар орон сууцжуулалт ХХК (З.Төмөртөмөө)-д		стэйт” ХХК шалгарч өмчлөгч иргэдтэй 2 болон 3 талт гэрээ байгуулах ажлын явц 90,7%-тай, Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан, Загвар зураг, ажлын зураг хийгдсэн, техникийн нөхцлүүд батлагдсан. Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 1-48, 2-48, 4-48 дүгээр байрны иргэдийн санал 100% боловч Төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтыг 2 удаа зарласан ч барилгын компани оролцоогүй, Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах СТ-4 дүгээр байрыг буулган дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр “Гартаам Агат” ХХК шалгарч барилгыг шинээр эхлүүлэн 2 блок 16 давхар барилга цутгалтаа бүрэн авч цонхны угсралтын ажлын явц 50%-д хүрээд байна.	
4	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлд	1	1	“5.Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний хүрээнд Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 5 дугаар байрыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааны тухай Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Орон сууцны дэд бүтцийн хэлтсийн	Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК	Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 5 дугаар байрыг буулган дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр “Такай хөгжил контрактш” ХХК сонгон шалгаруулалтаар шалгарч Батламжлагдан иргэдтэй харилцан тохиролцох 2 болон 3 талт гэрээ хийх ажил хийгдэж байна. Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг батлагдсан бөгөөд тайлант хугацааны зорилтод түвшинд хүрч бүрэн хэрэгжиж байна.	90%

				дарга Г.Ганхүү танилцуулав. Энэ асуудалтай холбогдуулан: Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч батламжлах тухай асуудлыг хэлэлцээд Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 5 дугаар байрыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК (З.Төмөртөмөө)-д даалгав.”		
5	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлд:	1	1	“5а.Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний хүрээнд Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны 6 дугаар байр, 6 дугаар хорооны 44 дүгээр байрыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааны тухай асуудлыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Орон	Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны 44 дүгээр байрыг буулган дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр “Гүмүда констракшн” ХХК шалгарч иргэдтэй харилцан тохиролцох 2 болон 3 талт гэрээ хийх ажил хийгдэж байна. Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг батлагдсан. 4 дүгээр хорооны 6 дугаар байрыг буулган дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр “Хөх бүрдний эх” ХХК шалгарч иргэдтэй харилцан тохиролцох 2 болон 3 талт гэрээ хийх ажил хийгдэж байна. Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг батлагдсан болно. Тайлант хугацааны зорилт бүрэн хэрэгжсэн.

90%

				сууцны дэд бүтцийн хэлтсийн дарга Г.Ганхүү танилцуулав. Энэ асуудалтай холбогдуулан: Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны 6 дугаар байр, 6 дугаар хорооны 44 дүгээр байрыг тус тус буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК (З.Төмөртөмөө)-д даалгав.”			
6	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлд	1	1	“56.Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 48, Нефтийн 1, 2, 3 дугаар байр, 22 дугаар хорооны 1-36, 2-36 дугаар байр байрыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааны тухай асуудлыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Орон сууцны дэд бүтцийн хэлтсийн дарга Г.Ганхүү танилцуулав. Энэ асуудалтай	Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК	Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 48 дугаар байр, Нефтийн 1, 2, 3 дугаар байр, 22 дугаар хорооны 1-36, 2-36 дугаар байруудын иргэд, сууц өмчлөгчидтэй хоёрлосон уулзалтыг хийж дахин төлөвлөлтийн талаар танилцуулга, мэдээлэл өгсөн. Архитектур төлөвлөлтийн даалгаврууд бүгд батлагдсан. Тус байршлын төслийг хэрэгжүүлэх дээд газрын шийдвэр НЗД-ын 2025 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн А/635 дугаар захирамжаар гарсан бөгөөд хэрэгжилтийн зорилтот түвшин бүрэн хэрэгжсэн байна.	90%

				холбогдуулан нь: Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 48, Нефтийн 1, 2, 3 дугаар байр, 22 дугаар хорооны 1-36, 2-36 дугаар байрыг тус тус буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК (З.Төмөртөмөө)-д даалгав.”			
7	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлд	1	1	“5в.Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний хүрээнд Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 1, 2, 3, 5, 6, 7 дугаар байр, 20 дугаар хорооны нутагт дэвсгэрт байрлах БХ 1-27, БХ 2-27, ТТЭ-37, ОС-8, АТ-12, БХН-48, БХН-30 дугаар байрыг буулган шинээр	Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК	Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 1, 2, 3, 5, 6, 7 дугаар байрыг буулган дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр “Саруул Оч” ХХК шалгарч иргэд сууц өмчлөгчидтэй 2 болон 3 талт гэрээ байгуулах ажил эхэлсэн, 20 дугаар хорооны нутагт дэвсгэрт байрлах БХ 1-27, БХ 2-27, ТТЭ-37, ОС-8, АТ-12, БХН-48, БХН-30 дугаар байрыг буулган дахин барилжуулах сонгон шалгаруулалтыг 2025.12.01-ээс зарласан байгаа. Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. Иргэд, сууц өмчлөгчидтэй хоёрлосон уулзалтыг хийж дахин төлөвлөлтийн талаар танилцуулга, мэдээлэл өгсөн.	90%

				барилгажуулах үйл ажиллагааны тухай асуудлыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Орон сууцны дэд бүтцийн хэлтсийн дарга Г.Ганхүү танилцуулав. Энэ асуудалтай холбогдуулан: Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 1, 2, 3, 5, 6, 7 дугаар байр, 20 дугаар хорооны нутагт дэвсгэрт байрлах БХ 1-27, БХ 2-27, ТТЭ-37, ОС-8, АТ-12, БХН-48, БХН-30 дугаар байрыг тус тус буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК (З.Төмөртөмөө)-д даалгав.”			
8	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлд	1	1	“Бг.Абиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний хүрээнд Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 28, 29, 30 дугаар байрыг буулган шинээр барилгажуулах үйл	“Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК	Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 28, 29, 30 дугаар байрыг тус тус буулган шинээр барилгажуулах төслийг Нийслэлийн Засаг даргын тамгын газар шилжүүлэн авсан тул тус заалт манай чиг үүрэгт хамааралгүй болно.	-

			ажиллагааны тухай асуудлыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Орон сууцны дэд бүтцийн хэлтсийн дарга Г.Ганхүү танилцуулав. Энэ асуудалтай холбогдуулан: 1.Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 28, 29, 30 дугаар байрыг тус тус буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК (3.Төмөртөмөө)-д;		
--	--	--	--	--	--

ТАНИЛЦСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ГАЗРЫН ДАРГА  Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА  Ж.БАЛЖИННЯМ

НЭГТГЭСЭН:

ТОГТООЛ ШИЙДВЭР, ТӨЛӨВЛӨГӨӨ,
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Б.УНДРАХ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хяналтад авсан арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах, байгууллагын удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээний арга зүй.

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлээс байгууллагын үйл ажиллагаатай хамааралтай шийдвэр, зүйл заалтыг хяналтад авч, тэдгээрийн 2025 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийв. Хяналт-шинжилгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3 дугаар заалтыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээний газраас нийт 7 шийдвэрийн 8 заалтыг ирүүлснээс тус байгууллагад 8 дугаар заалт буюу манай байгууллагад эрх шилжиж ирээгүй хэрэгжүүлэх боломжгүй 1 төсөл байгаа тул тус шийдвэрийг хяналтаас хасуулах саналтай байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээг нийт 7 шийдвэрийн 8 зүйл, заалтыг дээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ба нийт дундаж хэрэгжилт **93,5** хувийн биелэлттэй буюу “**үр дүн гарсан**” гэж дүгнэж байна.

Дөрөв. Дүгнэлт.

Байгууллагын холбогдох хэлтсүүдээс хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй ажлууд хийж байгаа боловч биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлэх, ажлын гол үр дүнг товч тодорхой, баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.

Тав. Зөвлөмж, санал.

Цаашид холбогдох хэлтсүүдийн мэргэжилтнүүд баримт бичиг боловсруулах ур чадвараа сайжруулж, ирүүлж буй тайлангийн чанарт анхаарах, мэргэжилтний боловсруулсан тайлан, мэдээллийг харьяалах хэлтсийн дарга нар сайтар хянаж, арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ГАЗРЫН ДАРГА



Б.ПҮРЭВСҮРЭН

ЗАХИРГААНЫ ХЭЛТТСИЙН
ДАРГА

Балжинням

Ж.БАЛЖИННЯМ

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ЗАХИРГААНЫ АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Т.Энхмаа

Т.ЭНХМАА